

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД


Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэлд:

“Х.1.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай (хагас жилийн байдлаар)

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга нарт даалгав:

1.1. биелэлт хангалтгүй байгаа 70 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж 2017 оны жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх;

1.2. зорилт, арга хэмжээний биелэлтийг зарцуулсан хөрөнгийн хэмжээ, шалгуур үзүүлэлтийг тухайн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнтэй хамт тайлагнах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР